



## ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СҮМЫН “БОР-ӨНДӨР” БАГА СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 8/79

Бор-Өндөр

Г Ажилчдад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн  
урамшуулалт олгох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.3, 4.8, 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн гүйцэтгэлийн чанар, үр дүнг харгалзан ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй байдлыг харгалзан 2023 оны 04 дүгээр улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хавсралтад дурдсан нэрс, хувь хэмжээний дагуу олгосугай.
2. Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг 2023 оны 12 дугаар сард бодож олгохыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  ЧАМАРЖАРГАЛ

